



ӨВӨРХАНГАЙ ЛЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/108

Хужирт сум

Гүйцэтгэгчийг сонгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ажлын хэсгийн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 09 дүгээр зөвлөмжийн дагуу “Худаг засвар ӨВАХУСЗДТГ/202301013” ажлыг 12,000,000 (арван хоёр сая) төгрөгөөр “Баянговь-Ус” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ